

Текст ба утга учир (Value)

Гүрринчингийн Сүхбат 

*Монгол Улсын Боловсролын их сургуулийн Нийгэм, хүмүүнлэгийн ухааны сургуулийн
Монгол хэлний тэнхимийн багш, доктор (Ph.D), профессор, Улаанбаатар, Монгол Улс*

Хүлээн авсан - Received:

2025- 5-14

Засварласан - Revised:

2025-12-25

Хэвлэгдсэн – Published:

2025-12-31

Gursukhbat9@gmail.com

ORCID: [0009-0002-7859-813X](https://orcid.org/0009-0002-7859-813X)



© 2025, Author(s)

Хураангуй: Зарим нэг судалгааг хийхэд заавал гарт баригдах, нүдэнд үзэгдэх бодот, барим тавим нотолгоонд тулгуурлах албагүй, Г.Галилейн өгүүлсэн төлөөллийн загварыг ашиглан тайлбарлаж болох тухай санаанд тулгуурлан өмнө хийгдэж байсан судалгааны баримт дүгнэлтийг түшиглэж, аливаа текстийн хэлний (семиотикийн) үнэ цэн нь түүний бүрэлдүүлбэрийн байр харьцаа байдаг гэсэн өөрийн гэсэн дүгнэлт, гаргалгааг хийх зорилгоор энэхүү ажлыг бичсэн. Ингэхдээ текстүүдийн авиаг өнгөнд оруулж бүтцээр зураглаад тэдгээрийг сканердан санаж, мөн өнгийг сольж мөн тэрхүү бүтэц, харьцааг хэвээр хадгалахаар сканердан харьцуулахад үндсэн үр дүн, үнэ цэн хэвээр ижил гарна гэх таамгийг дэвшүүлсэн ба улмаар аливаа текст тогтолцоонд бүрэлдүүлбэр тус бүрийн хувь бодгаль онцлог гэхээсээ илүү харин тэдгээрийн харьцаа, байрын харьцаа хамгийн гол зүйл байдаг гэх

тодорхойлолтыг зохиогч хийж байгаа юм. Өгүүлж байгаа бичвэрт Ф.Соссюрын онол үзэл баримтлал, Данид ХХ зуунд нэлээд хүчтэй байсан Глоссематик үзэл хандлага (үндэслэгч нь Луй Ельмслев), тэдний хэл бол цэвэр хэлбэр гэж тэмдэглэсэн онол үзэл баримтлал, В.Гумбольдтын “Хэл бол хязгаарлагдмал тооны арга хэрэгслийг хязгааргүй ашигладаг (infinite use of finite means) тогтолцоо гэсэн үзэл баримтлал, авиа утгын холбоо хамаарал нь тодорхой чиглэлтэй, байршилтай гэх Н.Чомскийн үзэл баримтлал зэрэгт тулгуурлажээ. Дүгнэлтдээ хэлний текст төдийгүй мөн хөгжмийн текстийг ч визуаль хэлбэрээр судлах боломжтой тухай салбар хүрээнд хэрэглэж болох альтернатив шийдлийн талаар санаагаа илэрхийлсэн билээ.

Түлхүүр үг: Үнэ цэн, харьцаа, хэлний тэмдэг, фигур, ассоциаци

Удиртгал

Бид 2010 онд Авиаг өнгө болгосон оросын хэсэг судлаачдын материал дээр тулгуурлан, тэрхүү өгөгдлийг 120 хүний дунд судалгаа явуулан магадлаад, улмаар тэрхүү өгөгдөл дээрээ тулгуурлан *Хараалын үг хэллэг, Бэлгэ дэмбэрлийн үг хэллэг, Маанийн бичвэрүүдийг* тус тус өнгөт зурган ТЕКСТ болгон, хүмүүс болон бичил организм бүхий орчинтой биет дээр туршилт явуулж үзэхэд багагүй сонирхол татсан үр дүн гарч байсан.

1. Юуны түрүүнд авиаг өнгө болгон хувиргаж текстэд (энд нэхдэс гэх нь жинхэнэ утгаараа зөв ч байж мэднэ) шилжүүлсэн зураг нь тодорхой хэмжээгээр хүмүүст нөлөөлсөн, тэр нь тухайн бичвэрийн агуулгын талыг тусгасан байж болохуйц;

2. Өнгө болгож хувиргасан текстээс бүтээсэн зураг нь бичил орчин бүхий биетэд тодорхой хэмжээгээр нөлөөлсөн гэх үндэслэл бүхий үр дүн гарсныг дурдмаар байна. (Хэрвээ та бүхэн энэхүү өгүүлэлтэй танилцахыг хүсвэл Өнөөдөр сонины 2010 оны 11 сард гарсан дугаараас олж, улам тодруулан ойлголт авч болно. (Сүхбат, 2010)

Бид дээрх өнгө бүхий нэгэн төрлийн текстийн нөлөө нь тухайлсан өнгө гэж үзэхээсээ илүүтэй харин тэрхүү өнгөний хослол (гармони) байх талтай, тэр нь тодорхой байр шүтсэн, харьцаанаас хамаарсан бүрэлдэхүүнүүдийн зохирол байна гэж үзэж байгаа юм. Өөрөөр хэлбэл, текст, бүрэлдүүлбэрийн (өнгөний) зохирол бүхий тогтолцоо нь өөрөө үнэ цэн, утга учир бүхий хэсэг юм гэсэн санааг дэвшүүлж байна. Судалгааны ач холбогдол, дэвшүүлж буй асуудлын шинэлэг байж болох талыг товч дүгнэлт хэсэгтээ оруулав.

Судалгааны арга зүй

Судалгаа маань чанарын шинжилгээ хийхэд чиглэсэн, харилцан хамаарлын судалгаа, мөн тодорхойлох судалгаа болох болов уу. Энд зохиогч текст, семиотик, хэлний утга учир (value, значимость, ценность), математик харьцааны талаарх холбогдох мэдээ баримтад тулгуурлан, ажиглах, зэрэгцүүлэх, анализ хийх, тодорхойлох аргуудыг ашигласан.

Хүний нотлох баримт туршлага хязгаарлагдмал мөртлөө түүнээс хэтийдсэн асар их зүйлийг мэдэж чадаад байдаг тухай буюу хүний мэдлэг туршлагын харьцаа хамаарлын тухай дэвшүүлсэн асуудлыг плато проблем гэсэн ойлголтоор тайлбарладаг (Мөнхцэцэг бас бус, 2022) Мөн энэ тухай Г.Галилей хүний ердийн мэдрэхүйгээс хэтийдсэн, зарим тайлагдаагүй ертөнцийг судлахад заавал гарт баригдах, нүдэнд үзэгдэх бодот, барим тавим нотолгоонд тулгуурлах албагүй, Г.Галилейн хийсэн төлөөллийн загварыг ашиглан тайлбарлаж болно гэсэн санааг Н.Чомский хэл шинжлэлийнхээ онол аргазүйн үндэс болгожээ (Мөнхцэцэг ба бус, 2022) гэснийг эш татаад, сүүлийн үед хиймэл оюун ухааны платформууд дээр хийгдэж байгаа үйл олон жил бодож явсан таамгийг минь улам ч баталж байгаа мэт тул дараах санааг хуваалцах гэсэн билээ.

Үндсэн хэсэг

Хэрвээ Судлаач Ю.В.Кнозоровын Майяачуудын бичгийн бүхий л тайлал уншварыг хөмрөгт оруулан сан үүсгээд, тодорхой зохион байгуулалтад оруулсны дараа “сканердах зарчмаар” үр дүнг тооцон гаргасан хойно майяачуудын бүх олдвор бичээсийг мөнхүү үүтгэсэн талбай дээрээ оруулж мөн үр дүнгээр цахим ухаалаг орчинд “сканердан таних зарчмаар” нийлүүлбэл уншигдаагүй текстүүд төвөггүй уншигдах болов уу.

Хэрвээ тодорхой биеийн онцлог бүхий хүмүүсийн датаг үүсгэн ямар нэг байдлаар зурган эсвэл хэмжээст датаг гаргаж харьцуулан гаргасан үр дүнг хөмрөгт оруулж сан үүсгээд мөн тодорхой зохион байгуулалтад оруулан “сканердах зарчмаар” үр дүнг тооцон гаргасан хойно тодорхой хүмүүсийн дүр зургийн олдворыг “сканердах зарчмаар” жишин уншвал мөнхүү хүний тухай текст, тодорхойлолтыг төвөггүй гаргаж авах магадлалтай.

Хэрвээ тодорхой нэр бүхий зураачийн бүтээлийн датаг үүсгэн хиймэл оюун ухаанд бүтцийн хувьд таниулж санаад, хөмрөг үүсгэж тодорхой зохион байгуулалтад оруулсан

хойно ямар нэг маргаан эргэлзээ бүхий зургийг мөн л скайнердан таних зарчмаар уншвал таамаглаж байсан зураачийнх мөн эсэхийг шийдэж болох магадлалтай.

Хэрвээ текстүүдийн авиаг өнгөнд оруулж бүтцээр зураглаад тэдгээрийг сканердан санаж, мөнөөх өнгийг сольж мөн тэрхүү бүтэц, харьцааг хэвээр хадгалахаар сканердан харьцуулахад үндсэн үр дүн үнэ цэн хэвээр ижил гарна... хэмээгээд нэгэн дүгнэлт хэлбэл: Аливаа юмсын утга учир, үнэ цэнг (value) тодорхойлох зүйл бол бүрэлдүүлбэр тус бүрийн хувь бодгаль онцлог гэхээсээ илүү харин тэдгээрийн харьцаа, байрын харьцаа байна гэх дүгнэлтийг хийж байна. Жишээлбэл: $a^2+b^2=c^2$ гэх нь угтаа хоёр катетын квадратын нийлбэр гипотенузын квадраттай тэнцэнэ гэсэн шүү харьцааны утга учир нь дээрх a, b, c гэсэн хувьсагчийг өөр үсгээр тэмдэглэхэд харьцааны үнэ цэн алдахгүй байх юм гэдэгтэй ижил.

Ингээд энэ бүхнийг тайлбарлах үүднээс хэд хэдэн зүйлийг энд эш татан дурдмаар байна. А.Н.Колмогоров “Математик гэдэг бол бодот ертөнцийн тоон харьцаа хийгээд орон зайн хэлбэрийн тухай шинжлэх ухаан юм” (Колмогоров, 1954) хэмээн тодорхойлжээ. Мөн ... орон зайн хэлбэр, тоон харьцааг анхлан судлах ухаан гэсэн шүү (Осипов, 2004-2017) харьцангуй сүүлийн үеийн ойлголтоор бол үл мэдэгдэх объектуудын харьцааг судалдаг ухаан гэх тодорхойлолт бас байна.

Түүнчлэн “Математик бол бусад шинжлэх ухаануудын харьцах хэлний хэрэглүүр болж, тэдгээрийн бүтцийн харилцан холбоог илрүүлэх, улмаар оршихуйн хамгийн түгээмэл хуулийг нь нээдэг суурь шинжлэх ухаан юм” (Сибирский открытый университет, 2012) гэсэн тодорхойлолт ч мөн байна.

Ф.Соссюрын хэл шинжлэлд төдийгүй бүхий л шинжлэх ухаанд оруулсан том хувь нэмэр бол тэмдгийн тухай сургаалыг боловсруулсан явдал юм. Товчхондоо бол Фердинанд Соссюр эцэст нь хэлний тэмдэг гэдгийг (өөрөөр хэлбэл утга илэрдэг тэр зүйл) ямар нэг физиологийн хийгээд сэтгэлзүйн эсвэл нийгмийн хүчин зүйлээс салгаж, хэлний тэмдэг хийгээд утга хоёр нь бүхэлдээ болзмол зүйл, түүний илэрхийлдэг зүйлтэй ямар нэг бодот холбоо байдаггүй талаар мэдэгдэж, “алдарт шатрын жишээ”-гээрээ үүнийг тайлбарласан байна. Жишээ нь, шатрын морь байна. Энэ нь ямар нэг бодот морьтой холбоотой бус, тоглоход бол мөнхүү фигурт шингэсэн тодорхой шинжүүд л чухал юм. Хэрвээ та тэрхүү морийг хаа нэг газар гээчихлээ гэхэд түүний оронд ундааны таглаа аваад оронд нь тавьчихсан байлаа гэхэд бараг өмнөхөөсөө илүү үүргээ гүйцэтгэж мэдэх тийм шатрын морь л байх болно. Тодруулбал, фигурт орших байрлалын эсрэгцэл, харын талын бод богтой эсрэгцэх байр, цагааны талын бог бодтой эсрэгцэх байр, шатрын хөлгийн хоёр хэмжээст байруудын эсрэгцэлд түүний үнэ цэн тодорхой болно гэвэл сая ойлгомжтой болно.

Эндээс “хэлний тэмдгийн өөр нэг аспект нь тэдгээрийг бүрдүүлдэг зүйлс бол ялгаа юм” гэх ойлголт зүй ёсоор гарч ирнэ. Тодруулбал, ялгарал бол хувь бодгаль онцлог гэхээсээ илүүтэй байршлын харьцаа дээрх зэрэгцүүлэл, харьцуулал болж байна (Ф.Соссюрын энэ байр суурь хэлний тэмдгийн тоо томшгүй баримтын олонлогоос ангижруулж түүнийг илүү хийсвэрлэн сэтгэх боломжтой болгосон, тийм ч болохоор бодот тодорхой авианы олонлогоос ялгарах тодорхой онцлог бүхий фонемын тухай ойлголт бий болсон).

Глоссематик бол Данид 20-р зуунд хөгжжээ. Үндэслэгч нь Луй Ельмслев, Виго Брёндаль бөгөөд мөн төлөөлөл нь Отто Исперсен, Ханс Иёрген, Хольгер Педерсен, Кнуд Тобегю,

Йорген Ульдалль, Пауль Дидерихсен, Хеннинг Спан-Хансен, Эли Фишер-Йоргенсен нар юм. Тэд тухайн цагтаа нэлээд анхаарал маргаан дагуулдаг байсан, хэл шинжлэлийг уламжлалт сонгодог байр сууриас формаль логик тал руу нь шилжүүлсэн гэж болох Соссюрын сургаалыг улам боловсруулан хөгжүүлсэн гэж болно.

Л.Ельмслев нь хэл шинжээч хэлээр дамжуулж бүхий л юмсыг, нийгмийн түүхийг, хүний сэтгэл зүйг, авианы анатомыг мэдэж болно хэмээн үзсэн бололтой байдаг. Тэрээр тодорхой бодгаль хэлнүүдийн хэсэг бусаг тодорхой баримт сэлтийг төдийлөн сонирхож байсангүй, харин хэлний онол бол аль болох ерөнхий байх ёстой, ингэхдээ нэг зарчимд үндэслэж байх, тодорхой дэс дараанд авч үзэх ёстой гэх асуудлыг тэргүүнд тавьж байсан юм.

Хэлний авиан хэлбэрийг тэмдэглэсэн илэрхийллийн тал, хэлээр илэрч байгаа утга учрыг тэмдэглэсэн агуулгын тал гэдэг нэр томъёог чухамдаа Л.Ельмслев л санал болгосон юм. Чингэхдээ агуулгын тал гэдэгт ойлгож ухаж болох бүхий л зүйлсийг субстанции гэнэ гээд харин хэлний хэлбэрт тухайн хэлэнд тохирсон утга учрыг эрэмбэлэх арга юм гэж үзэж байв.

Түүний тодорхойлсон бас нэг чухал ойлголт бол фигур юм. Энэ бол тэмдгийн хэсэг болдог тэмдэг бус зүйлсийг хэлсэн хэрэг гэх бөгөөд тодруулбал ганцаараа байхдаа юуг ч илэрхийлэх боломжгүй харин цогцоороо байхдаа үгийн янз бүрийн утгыг бүтээж байдаг, үгийн утгын бүрэлдүүлбэр гэж үзсэн хэрэг.

Тэмдэг гэдэг бол хэлбэр хийгээд агуулгын холбоон дээр үүсэх үр дүн гээд гэхдээ тэмдэглэгдэгч заавал бодитой байх шаардлагагүй гэжээ. Түүнчлэн Л.Ельмслев хэл бол цэвэр хэлбэр гэж тэмдэглэжээ (Тийм болохоор ямар ч тэмдгийг нөгөөгөөр сольсон ч систем тогтолцоо нь үргэлжлэн ажиллаж л байх тийм цэвэр хэлбэр юм).

Тэр бүгдийг харгалзан дүгнэхэд, утга учир, үнэ цэнийг тодорхойлдог бүрэлдүүлбэрүүд гэж байх агаад тэдгээр нь ямар ч байж болно, гагцхүү харьцааг зааж байгаа байршил яг хэвээр байхад бүрэлдүүлбэрүүд өнгө шинж их бага хэмжээгээр хамтдаа нэгэн ижил хэмжээгээр өөрчлөгдсөн байхад үр дүн хэвээр байна. Жишээ нь текстийн авиан бүрэлдүүлбэрүүдийг өнгөд хувирган мөн байранд өнгөний шинжийг ижлээр өөрчлөхөд утга учир, үнэ цэн хэвээр байна гэсэн үг хэмээн бид үзэж байгаа юм.

Тодруулах үүднээс дахин нэг жишээ татъя. Сүүлийн үед хар цагаан фотог өнгөт болгон сэргээж байна. Тэрхүү арга технологийн үндэс бол ахромат өнгөнүүдийн харьцаа бөгөөд тэдгээрийн харьцаан дээр хроматик өнгийг сэргээн гаргаж буй нь чухамдаа зураг өөрөө текст хэмээн үзвээс түүний үнэ цэн мөнөөх өнгөнүүдийн тогтсон харьцаан дээр л хадгалагдсан болж таарна.

Эндээс аливаа бүтцүүдийн датаг цуглуулж хянан нягталж, нэг платформ дээр дээрээс скайнердах зарчмаар бусад ижил төстэй зүйлсийн утга учир үнэ цэнийг тодорхойлж болно гэсэн бидний дээр тодорхойлсон гаргалгаа гарах ба үүний гол үндэс нь тухайн текстийн (энд текстийг бүх зүйлийг хамруулсан өргөн утгаар нь авч үзэж байна) бүрэлдүүлбэрүүдийн байрлал юм гэсэн гол дүгнэлтийг гаргаж болно. Үүнтэй холбогдуулан нэгэн жишээ баримт татахад, ген бол мэдээлэл хадгалагч гэдгийг бид мэднэ. Гэхдээ тэрхүү мэдээллийн үнэ цэнийг гений бүрэлдүүлбэрүүдийн дэс дараа шийдэх юм. Өөр юу ч биш.

Зарим нэг баримтуудыг түүвэрлэн хэлэх гэсэн санаатайгаа холбон тайлбарлах гэж оролдъё. В.Гумбольдт “Хэл бол хязгаарлагдмал тооны арга хэрэгслийг хязгааргүй ашигладаг (infinite use of finite means) тогтолцоо юм гэжээ. Тодруулан өгүүлэх аваас цөөн тооны хэлний бүрэлдүүлбэр байр сэлгэн байрлаж олон сая мэдээлэл илэрхийлдэгтэй адил юм. Дашрамд дурдахад тэрхүү байрлалд байх бүрэлдүүлбэрүүд багаас том нэгж (өгүүлбэр, догол, текст) хэсэг болон ахисан ч бүтэц байрлалаас хамаарсан үнэ цэнийг хадгалж байх юм. Тэгвэл Ф.Соссюр хэл бол (langue) юмсын тогтолцоот олонлог/цогц бүрдэл юм хэмээн тодорхойлсон байна. Өөрөөр хэлбэл, тогтолцоог тодорхойлдог хамгийн гол зүйл бол харьцаа юм гэсэн санааг үүнтэй холбож хэлмээр байна. (Харьцааг үүсгэж байгаа нийлцийн бүрэлдүүлбэрүүд ямар ч байж болно. Гагцхүү тэрхүү байрандаа харьцаандаа тогтвортой байвал үнэ цэн утга учир хэвээр байх болно. Жишээ нь, улаан өнгийг ногоон өнгөөр мөн тэр байрнуудад харьцааг нь алдахгүйгээр сольж тавихад түүнээс тусгал авсан үр дүн хэвээр байх болно гэсэн санааг давтан хэлэх гэсэн юм). Н.Чомский авиа утгын холбоо хамаарлыг дүрслэхдээ “хүний сэтгэхүйн тооцооллын систем нь нэг чиглэлдээ утгыг авианы дараалалтай холбож, нөгөө чиглэлдээ, авианы дарааллыг утгатай холбодог” гэжээ. Өөрөөр хэлбэл, утга ба авианы дараалал буюу утга учир харьцаа байршил, харьцаа байршил утга хүний сэтгэхүйн тооцооллын систем гэсэн хэлхэц бий болж байгааг харж болно. Энэ бол бидний хэлний текстийн үнэ цэн бол цэвэр харьцаанаас хамаарна гэдгийг харуулж байна. Тооцооллын систем гэдгийг хэрхэн тодорхойлсон болохыг мөн бид харж болох юм. Хэрвээ тооцооллын системийн үндэс нь математик юм бол мэдээж харьцаа гэдэгт түүний тодорхойлолт төвлөрөх нь ойлгомжтой байх, учир нь бидний дээр авч үзсэн математик гэх тодорхойлолт нь харьцаа хамаарлыг тооцдог л ухаан болж таарч байсан. Улмаар Н.Чомский “Авианы хэлбэр ба логикийн хэлбэр нь хэл ба танин мэдэхүйн бусад тогтолцоонуудын уулзвар холбоо (interface)-г бүрдүүлж, нэг талаас, авианы шууд төлөөллийг, нөгөө талаас, утгын шууд төлөөллийг гарган илэрхийлж, хэл ба бусад системийн харилцан үйлчлэлд оролцдог байна” гээд хэл эзэмшихүйн тухайд авч үзвэл хүүхэд тухайн хэлний авиа болон утгыг биш харин тэдгээрийг холбогч тооцооллын системийн хэрэглүүр болох өгүүлбэр зүйн бүтцийг хэрхэн эзэмшдэгийг судлах нь хэл шинжлэлийн гол асуудал юм гэж үзжээ. (Мөнхцэцэг ба бус, 2022). Энд хэл гэдэг бол харилцан үйлчлэл бүхий харьцаа бөгөөд тэрхүү харьцааны нэг элемент байхгүй тохиолдолд хүн өөрийн бэлэн загвар дээр шууд сэтгэж болдог тухай баримтыг жишээлэн тайлбарламаар байна. Харьцаа байгаа учраас түүнийг, өөрөөр хэлбэл, харьцааны байх ёстой тэрхүү загварыг сэргээн нөхөж сонсогч этгээд ойлгоно. Тодруулбал, бүрэн өгүүлбэр, бүрэн бус өгүүлбэр, мөн нутгийн аялгуундах авианы сэлгэцийг хүлээн авагч этгээд өөрийн хэлний бүрэлдүүлбэрийн харьцааг сэргээн буулгах зарчмаар шууд ойлгож хүлээн авдаг гэж болно. Хүн юм мартахаараа санах гэж хичээхдээ тэр үгийн эхний хэсгийг санахыг оролдох, мөн ассоциаци болох хам тогтолцооны хэсгийг дотроо санаж эхэлдэг нь мөн л харьцаа байрны тухайд холбогдох болов уу.

Декарт нарын рационалист философичдын дэвшүүлсэн “хүний сэтгэхүйд төрөлх санаа байдаг” гэх үзэл бий. “Хүнд төрөлх санаа байдаг” гэх Платон Декарт нарын үзлийг дэмжигч рационалист философич Лейбницнхаар хүний сэтгэхүйд санаанууд (ideas) ба үнэн (truths) гэх ойлголт төрөлх шинжтэй байдаг... Өөрөөр хэлбэл хүний эзэмшдэг мэдлэг нь түүний сэтгэхүй дэх төрөлх санаануудаас үүдэлтэй... гэсэн байдаг. Чухамдаа үүний цаад уг шалтгаан нь хүний өөрийнх нь хүртэхүй мэдрэхүйтэй мөн холбогдох ёстой гэж үзэж болох юм. Өөрөөр хэлбэл, тэрхүү төрөлхийн мэдлэг тогтон тогтворжих нь мөнхүү хувь хүний өөрийн бодгаль шинжтэй холбоотой гэсэн ойлголт юм. Ялангуяа энэ бол дээр

дурдсан өнгөний мэдрэмж дээр тун ч тодорхой болох ёстой. Тодруулбал, н.Сүхбат миний мэдэрч байгаа ногоон өнгийг н.Туул гэх эмэгтэй цэнхрээр мэдэрч болох (бөгөөд гэхдээ үүнийг судалбал судалгааны чамгүй ач холбогдолтой судлагдахуун болно), үүнээс шалтгаалж хүн хүний сэтгэл зүй, авьяас мэдрэмжийн хандлага өөр өөр байх магадлалтай юм. Тийм болохоор тогтолцоонд тухайн өнгөний байрлал, түүнээс үүдсэн үнэ цэн чухал болохоос өнгө өөрөө чухал биш гэдэг гаргалгааг хийж байгаа юм. Юуны түрүүнд хүн бүхэн өнгийг нэг мэдрэмжээр хардаггүй байж болно хэмээн бид үзэж байна.

Хэл зүйг тодорхойлох хамгийн гол зүйл бол байрлал юм гээд дахин нэг тайлбар хийе. Өгүүлбэр болгон хэрэглэх үед хэл зүйн хэлбэр хэрэглэх, тодруулбал нэгэн төрлийн тодотгогч авна (үүнийг хэл шинжлэлд хэл зүйн хэлбэр гэнэ). Заахын тийн ялгалын нөхцөл бол тэрхүү тодотгогч юм. Уг нь бол “Би Дорж цохилоо” гэж гадаадын иргэн хэлэхэд монгол хүн төлөв ойлгоно. Гэтэл “Би Дорж цохилоо” гэдэг нь заавал ЗТЯ-ын ил хэлбэр авч тодотгогдох хэрэгтэй бол “Би мод цохилоо” гэхэд ЗТЯ-ын ил хэлбэр шаардахгүй байна. Энд тодотгогчийн асуудал гарч байгаа юм. “Би ном уншлаа”, “Би хүрз авлаа”, “Би цэцэг усаллаа” гэхэд үнэндээ S ба О нь байршлаараа тодорхой байна. Харин Би Дорж(ийг) цохилоо гэхэд заавал тодотгогч шаардаж байгаа нь үнэндээ тэнд хоёр үйлдэгч (S1: S2) байгаа, тэр хоёрыг ялган тодруулахад л оршиж байгаа болов уу. Өөрөөр хэлбэл, монгол хэлний өгүүлбэрийн S ба О нь хоёулаа үйлдэгч байх аваас тодотгогч буюу ЗТЯ-ын ил хэлбэрийг авах шаардлагатай болно гэж бодож байна. Энд гол тодорхойлж байгаа зүйл бол тэгэхээр харьцаа л байгаа юм. Харьцаанаас мөн хамаарч тийн ялгалын бусад хэлбэр тодотгогчийн үүрэг гүйцэтгэнэ гэсэн үг. Би Дархан (0) явлаа. Би Дархан (аас) явлаа гэх мэт.

Уг нь хэлийг цэвэр логик талаас харвал S ба О хоёр л гол бүрдүүлэгч бөгөөд энэ нь үнэндээ ертөнцийн бодот зургийг үүсгэнэ. Харин Р бол үйл гэхээсээ илүүтэй харьцаа заагч юм. Бодот ертөнцийн логикоор бол Дорж байна, хүрз л байна. Тэдгээрийн хооронд харьцаа үүснэ. Түүнийг л Р-ээр илэрхийлж байгаа хэрэг. Ертөнцөд зөвхөн юм л байна, түүний харьцаа л байна. Өөр юу ч байхгүй гэсэн үг. Харин хэлний мэдлэг болох цагт шинжийн тухай асуудал яригдаж болно. Тэр нь янз бүрийн шинж заасан хавсрал нэрүүд, орон заасан нэрс байх бөгөөд харин хэл зүйн хэлбэрүүд бол нэгэн төрлийн тодотгогчууд л юм.

Дүгнэлт

1. Аливаа текстийн утга учир үнэ цэн тухайн систем тогтолцооныхоо байр шүтдэг.
2. Аливаа текстийн байршил дахь бүрэлдэхүүний элементийг мөн тогтолцооны байршил тогтолцоог хадгалж байхаар өөрчлөхөд үнэ цэн, утга учир хэвээр байна.
3. Бидний хардаг мэдэрдэг өнгө шинж биднээр л хэмжигдэнэ, өөр хэн нэгнээр хэмжигдэхгүй.
4. Хэлний текст төдийгүй мөн хөгжмийн текстийг өнгөт палитр болгож, визуаль хэлбэр аргаар судлах боломжтой буюу тухайн салбар хүрээнд хэрэглэж болох альтернатив шийдэл байж болно.
5. Авиа ба өнгөний синестези гэх ойлголтыг цаашид үргэлжлүүлэн, чингэхдээ уламжлалт хэл шинжлэл, махбодын онол, хөгжмийн урлагийн судлал, дүрслэх урлаг, өнгө судлалын ухаан зэрэгтэй холбон гүнзгийрүүлэн судлах хэрэгцээ шаардлага зүй ёсоор байна.

Text and Value

Sukhbat Gurrinchin 

*Professor of the Department of Mongolian language,
Mongolian National University of Education, Ulaanbaatar, Mongolia*

Abstract: In 2010, our research team began exploring an unusual question: could the fundamental value of texts lie not in their individual components but in the relationships between them? Inspired by Galileo's notion that some phenomena can be understood through representational models rather than direct observation, we developed an experimental approach converting textual sounds into colours. Working with 120 participants in Mongolia, we mapped curse words, words of blessing, and mantras into visual patterns, maintaining their structural relationships while varying the actual colours used. Surprisingly, we found that changing colours while preserving positional relationships produced consistent effects on both human subjects and, intriguingly, microorganism cultures. This unexpected stability reminded us of mathematical relationships like $a^2+b^2=c^2$, which remain true regardless of variable notation. Our findings align with theoretical insights from Saussure's chess piece analogy—where meaning derives from position, not physical form—and resonate with Hjelmslev's concept of language as "pure form," Humboldt's "infinite use of finite means," and Chomsky's computational approach to syntax. While preliminary, these results suggest potential applications in deciphering historical scripts (we specifically considered Mayan texts), authenticating artworks, and developing pattern recognition systems. Most fundamentally, this work proposes that textual meaning may emerge from relational patterns rather than constituent elements—a perspective that could offer new visual methodologies for analysing both linguistic and musical texts, though further validation is clearly needed.

Keywords: *Value, relations, linguistic sign, figure, association*

Ном зүй - References

Осипов, Ю. (2004-2017). *Большая российская энциклопедия*. Москва.

Сүхбат, Г. (2010). *Авиа ба өнгөний синтез*. Улаанбаатар.

Мөнхцэцэг, Н., Мөнх-Учрал, Э., Эрдэнэ-Очир, Т. (2022). *Монгол хэл судлал, XV боть, Хэрэглээний хэл шинжлэл, хэл боловсруулалт*. Улаанбаатар.

Сибирский открытый университет. (2012 оны 10 2025). *Математика как язык науки*. Архив: <https://web.archive.org/web/20120124064125/http://ou.tsu.ru/hischool/filmatem/42.htm>

Колмогоров, А. (1954). *Большая Советская Энциклопедия, Математика*. . Москва.

